

ЖАЙКА-ийн Монгол дахь Төлөөлөгчийн Газрын мэдээллийн хуудас. 2018 оны 11 сарын дугаар.

Тэргүүн Мэдээ.

“УБ хотын ус дамжуулах, түгээх үйл ажиллагааг сайжруулах төлөвлөгөө”-г (төсөл) боловсруулж дуусав.



Өвсний үндэс ТХА-ны “Улаанбаатар хотын ус дамжуулах, түгээх үйл ажиллагааг сайжруулах төсөл”-ийн хүрээнд УБ хотын ус дамжуулах, түгээх үйл ажиллагааг сайжруулах төлөвлөгөөг боловсруулахад шаардлагатай мэдлэг, туршлагыг нэвтрүүлэх зорилгоор Японд болон Улаанбаатар хотод дадлага сургалтын арга хэмжээ зохион байгуулж ирсэн болно. 11 сарын 7-ны өдрийн үр дүнгийн тайлангийн хурлаар 3 жилийн хамтын ажиллагааны явцад боловсруулсан Улаанбаатар хотын ус дамжуулах, түгээх үйл ажиллагааг сайжруулах төлөвлөгөө”-г (төсөл) НЗДТГ болон холбогдох бусад байгууллагын 250 ажилтанд танилцууллаа. Хамтын ажиллагааны 2018 оны 12 сард дуусах боловч энэхүү төлөвлөгөө нь (төсөл) бодлогын түвшинд батлагдаж Улаанбаатар хотын ус дамжуулах, түгээх чадавхийг хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулна гэж найдаж байна.

Төслийн хэрэгжилт

“Хөрөнгийн зах зээлийн чадавхийг бэхжүүлэх төсөл”-ийн 2-р шат 2019 оны 3 сард хэрэгжиж эхэлнэ.



11 сарын 15-ны өдөр ТХА-ны “Хөрөнгийн зах зээлийн чадавхийг бэхжүүлэх төсөл”-ийн 2-р шатны хурлын протоколд гарын үсэг зурав. Тус төсөл нь 2019 оны 3 сараас эхлэн 3 жилийн хугацаанд хэрэгжих бөгөөд хөрөнгийн зах зээл дээр мөнгөн хөрөнгө босгох хэрэгслийг төрөлжүүлэх болон компанийн бондод хяналт, зохицуулалт тавих эрх бүхий байгууллага болох СЗХ-ны чадавхийг сайжруулах замаар олон нийтийн компанийн бондод итгэх итгэлийг нэмэгдүүлэх, ойлголтыг дээшлүүлэх зорилт тавьж байгаа юм. Уг төслийн эхний шатны хүрээнд (2014 оны 7 сараас 2017 оны 6 сар хүртэл) хөрөнгийн зах зээлийн хяналт, зохицуулалтын чадавхийг бэхжүүлэх, зах зээлд оролцогчдын ойлголтыг дээшлүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулснаар зах зээлд итгэх итгэлийг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулсан юм.

Иноүэ Нобору (Обихирогийн ХААИС-ийн дэд захирал) ХААИС-ын хүндэт профессор цол хүртлээ.



10 сарын 25-ны өдөр зохион байгуулагдсан ХААИС үүсгэн байгуулагдсаны 60 жилийн ойн арга хэмжээний үеэр малын халдварт өвчинтэй тэмцэхэд оруулсан олон жилийн хувь нэмрийг нь үнэлэн, SATREPS “Монгол оронд тохиолддог малын цусны шимэгч эгэл биетнээр үүсдэг өвчний тархалтын судалгаа, оношилгооны оновчтой арга боловсруулах төсөл”-ийн дэд удирдагч Иноүэ Ноборуд ХААИС-ийн хүндэт профессор цол олголоо. Иноүэ мэргэжилтэн халдварт өвчинтэй тэмцэх чадавхийг бэхжүүлэх тал дээр цаашид ч тус сургуультай хамтарсан судалгааг үргэлжлүүлэх хүсэлтэй буйгаа илэрхийлэв.

Шинрай төслийн хүрээнд Япон улсад сургалтанд хамрагдагдаад ирлээ.



Монгол улсын 3 сая хүн амын хагасыг 30 хүртэлх насны залуучууд эзэлдэг “Залуучуудын орон” боловч ТХА “Нийгмийн даатгалын үйл ажиллагааны чадавхийг бэхжүүлэх төсөл”(SINRAI)-ийн хүрээнд ирээдүйд явагдах нийгмийн насжилтад бэлтгэн тэтгэвэрийн тогтолцоог сайжруулах арга хэмжээ авч байна. 11 сарын 4-17-ны өдрүүдэд НДЕГ-ын 17 ажилтан Фүкүока мужийн нийгмийн даатгалын газарт зочлон НДШ-ийн төлөлтийг сайжруулах, харилцагчдад үзүүлэх үйлчилгээний чанарыг ахиулах талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээтэй танилцав. Түүнчлэн алслагдсан нутгийн нийгмийн даатгалын ажилтан ч хамрагдаж болох интернетийн сургалтын системтэй танилцан, өргөн уудам нутагтай Монгол улсад нэвтрүүлэх боломжийг судлах зэргээр үр дүнтэй сургалт болов.

ЖАЙКА-ын Төлөөлөгчийн газрын хуанлид оруулах гэрэл зургийн уралдаан болов.



ЖАЙКА-ийн Монгол дахь Төлөөлөгчийн Газар 2019 оны хуанлид оруулах гэрэл зургийг уралдаан зохион байгуулах хэлбэрээр шалгаруулсан юм. “Монгол орон ба Япон орон - Ард түмний итгэл сэтгэлийн холбоос” гэсэн сэдэвтэйгээр зохион байгуулагдсан уг уралдаанд 130 гаруй бүтээл ирүүлснээс Монгол, Япон хүүхдүүдийн нөхөрлөлийн нэгэн агшныг харуулсан Л. Ууганбаярын “Мөрөөдөлд хамтдаа” гэдэг бүтээл тэргүүн байрыг эзлэв. Гэрэл зургийн уралдаанд идэвхтэй оролцсон бүх хүмүүст чин сэтгэлээсээ талархал илэрхийлбэ.

Сайн дурын үйл ажиллагаа.

Сайн дурын гишүүдийн үйл ажиллагааны танилцуулга (Эрүүл мэндийн салбарт ажиллаж буй ЖАЙКА-гийн сайн дурын гишүүдийн “Солонго зөвлөл” -өөс зохион байгуулсан санал солилцох уулзалт)



11 сарын 12-ны өдөр, Монгол улсын эрүүл мэндийн салбарт ажиллаж буй ЖАЙКА-гийн сайн дурын гишүүдийн “Солонго зөвлөл”-өөс зохион байгуулсан санал солилцох уулзалт Хавдар Судлалын Үндэсний Төвд болов. Тус зөвлөл нь 2016 оноос хойш жил бүр ийм уулзалт зохион байгуулж байгаа бөгөөд эрүүл мэндийн салбарт ажиллаж буй ЖАЙКА-гийн сайн дурын гишүүд (сувилагч, нийгмийн эрүүл мэндийн сувилагч, хөдөлгөөн засалч, хөдөлмөр засалч гэх мэт) Монгол хамтрагчтайгаа нэг дор цугларч, илүү үр дүнтэй үйл ажиллагаа явуулах талаар санал солилцдог юм. Энэ удаагийн уулзалт нь сургалтанд хамрагдагсдыг бүгдийг оролцуулсан байдлаар явагдсан ба хэлэх гэж буй санаагаа ойлгомжтойгоор илэрхийлэх аргын талаар танилцуулсан. Цаашид оролцогчид тэдгээр аргыг өдөр тутмын үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлнэ гэдэгт итгэж байна.



ЖАЙКА-ийн Сургалт Төгсөгчдийн Холбоо

Хоккайдод болсон газар хөдлөлтийн гамшигт нэрвэгдсэн ард иргэдэд хандив өргөлөө

2018 оны 9 дүгээр сард Хоккайдод болсон газар хөдлөлтийн гамшигт нэрвэгдсэн ард иргэдэд дэмжлэг үзүүлэх зорилгоор ЖАЙКА-ийн Сургалт Төгсөгчдийн Холбоо 2 сарын хугацаанд хандив цуглуулах үйл ажиллагаа өрнүүлээ. Холбооны гишүүдийн нэг нь: “Бид хүнд нөхцөл байдалд орсон Хоккайдогийн ард иргэдэд чин сэтгэлээсээ туслах зорилгоор хандив цуглуулсан” хэмээн ярьсан юм. ЖАЙКА-нь 1960-аад оноос эхлэн Монголчуудыг Японд сургалтанд хамруулах үйл ажиллагааг явуулж ирсэн бөгөөд хоёр орны ард түмний бат бэх харилцаа холбоог улам бэхжүүлэх хүрээнд зохион байгуулсан тус холбооны гишүүдийн халуун дэмжлэг тусалцаанд талархал илэрхийлбэ.

事務所ナショナルスタッフが日本語で執筆！

コラム ～モンゴルの文化・生活事情紹介～ 「双子の靴下」

モンゴルでは双子の靴下が盗まれることがよくあります。皆さん、何故だかわかりますか？言い伝えによると、双子の靴下を家に持って帰ると、子供を授かるとか、赤ちゃんを育てているお母さんのオッパイが痛む時に双子の靴下で「治るように」とおまじないをすると痛みが和らぐ、などと言われているからです。私は双子を持つ母ですが、実際に靴下を何度も盗まれました！（ボヤナ所員）



Бие даасан захиргааны хуулийн этгээд Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага.(ЖАЙКА) Монгол дахь төлөөлөгчийн газар.

Бодь цамхаг, 7 давхар, Сүхбаатарын талбай 3, Улаанбаатар, Монгол улс

(Төв шуудан, шуудангийн хайрцаг: 682, Улаанбаатар 211213, Монгол улс)

Утас:+976-325939, 311329, Факс:+976-310845 Имэйл: mg_oso_rep@jica.go.jp